

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН 2016-2018 ОНЫ ТӨСВИЙН ДУНД
ХУГАЦААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТӨСӨЛ

УЛААНБААТАР ХОТ
2015 ОН

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

ТАНИЛЦУУЛГА

Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын товч танилцуулгын тухай

2015 оны 07 дугаар сарын 27

Улаанбаатар хот

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 1-д "Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын ажлын алба нь түүний Тамгын газар мөн" гэж заасан байдаг.

Монгол Улсын засгийн газрын 1993 оны 04 дүгээр сарын 25-ны "Нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газрын бүтцийг шинэчлэн тогтоох тухай" 65 дугаар тогтоолоор тамгын газар нь 81 орон тоотой дотроо 5 хэлтэс, 1 тасагтай, харьяа 9 дүүрэг, 9 дэргэдэх газартай үйл ажиллагаагаа явуулж байсан.

Монгол Улсын "Нийслэлийн эрх зүйн байдлын тухай" хуулийн 6 дугаар зүйлийн 2.4-т "Нийслэлийн Засаг дарга нь Улаанбаатаор хотын Захирагч байх бөгөөд тэрээр хотын аж ахуйг биечлэн зохион байгуулах, мэргэжлийн албадыг зохицуулан удирдах үүрэг бүхий хотын ерөнхий менежерийг томилон ажиллуулна, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба нь нийслэлийн Засаг даргын ажлын албанаас тусдаа байна" гэсэн заалтыг үндэслэн Монгол Улсын Засгийн газрын 1994 оны 12 дугаар сарын 28-ны "Улаанбаатар хотын захирагчийн ажлын албаны тухай" 229 дугаар тогтоолоор Нийслэлийн Засаг дарга нь Улаанбаатар хотын Захирагч байхаар тогтоосон.

Улаанбаатар хотын захирагчийн ажлын албыг 1995 оны 01 дүгээр сарын 01-нээс 2 албатай, 1 тасагтай, 47 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан. Үүнд:

-Барилга, хот байгуулалтын алба

-Үйлдвэрлэл үйлчилгээний алба

-Орон сууц хуваарилалтын тасаг

Энэ тогтоолоор Нийслэлийн Засаг даргын Тамгын газрыг 71 хүний бүрэлдэхүүнтэй, 4 хэлтэс, 1 тасагтай болгосон.

1996 оны 10 дугаар сарын 24-ний Засгийн газрын "Нийслэлийн засаг даргын Тамгын газрын бүтцийг шинэчлэн тогтоох тухай" 263 дугаар тогтоолоор орон тооны хязгаар 71, 4 хэлтэстэй, 15 хэрэгжүүлэгч агентлагтай байхаар тогтоосон.

2000 оны 11 дүгээр сарын 29-ний "НЗДТГ, ЗАА-ны бүтцийг шинэчлэн тогтоох тухай" Засгийн газрын 185 дугаар тогтоолоор НЗДТГ-ын орон тооны хязгаар 55 /ТЗУХ, ЭЗСБХ, СБХ, НХБХ, ХЗХ, ГХХАХ/ 6 хэлтэстэй, Захирагчийн ажлын албаны орон тооны хязгаар 43 /ИБХ, ҮҮХ, ХТХ, МХХ/ 4 хэлтэстэй байхаар тогтоосон.